






Хөхөөр хооллолт сайн байгаагаа би хэрхэн мэдэх вэ?

- Доорх багануудад зөв тэмдэг (✓) тавьж бөглөөрэй.
- Хэрэв улаан хэсэгт нэг болон түүнээс олныг зөвөөр тэмдэглэсэн бол Эх баригч эсвэл, Хүүхэд ба Гэр бүлийн Эрүүл мэндийн Сувилагчтайгаа хүүхдийнхээ хөхөөр хооллолтын талаар ярилцаж зөвлөгөө болон тусламж аваарай.
- Та болон таны хүүхэд хэрэгтэй тусламж дэмжлэгээ эрт авах нь чухал.

Mongolian

😊 Дараах тохиолдолд хөхөөр хооллолт сайн байна гэсэн үг:	✓	☹️ Та дараах тохиолдолд Эх баригч эсвэл Хүүхэд ба Гэр бүлийн Эрүүл мэндийн Сувилагчтай ярилцана уу.	✓
Та хүүхдээ 24 цагийн дотор 8 ба түүнээс олон удаа хөхүүлдэг.		Хүүхэд тань унтаа, мөн 24 цагт 6-аас цөөн удаа хөхөө хөхөж байгаа бол.	
Таны хүүхэд хөхөө хөхөх бүртээ 5-аас 40 минутын турш хөхдөг.		Таны хүүхэд хөхөх бүртээ тогтмол 5 минут ба түүнээс богино хугацаагаар хөхдөг бол. Эсвэл хөхөх бүртээ тогтмол 40 минутаас урт хугацаагаар хөхдөг бол.	
		Хүүхэд тань дандаа хөхөө хөхөж байхдаа унтдаг бөгөөд/эсвэл хөхөж дуусгадаггүй бол.	
Хүүхдийн арьсны өнгө хэвийн.		Таны хүүхэд шарласан харагдвал (арьсны өнгө шар болох). Шарлалт нь ихэвчлэн хүүхдийн нүүрнээс эхлээд, дараа нь бие, гар, хөл рүү тархдаг. Хэрвээ энэ байдал нь бүр дордох, эсвэл хүүхэд тань унтаа байгаад байвал Хүүхэд ба Гэр бүлийн Эрүүл мэндийн Хөхөөр хооллолтыг дэмжих клиник эсвэл GP дээрээ очоорой.	
Хүүхэд тань хөхөх үедээ тайван, амгалан байх ба хөхснийхөө дараа ихэнхдээ жаргалтай байдаг.		Хүүхэд тань хөхүүлэх үед дундуур нь таслаад, эсвэл хөхөх дургүй байвал.	
Таны хүүхдийн живх шээс, баастай болсон байдаг. (арын хуудасны хүснэгтийг хараарай)		Таны хүүхэд живхэндээ шээж, баахгүй байвал (арын хуудасны хүснэгтийг хараарай).	
Хөхөөр хооллох нь танд тав түхтай байдаг.		Таны хөх эсвэл хөхний толгой хөндүүрлэж, хүүхэд тань хэд сорсны дараа ч зүгээр болохгүй байвал. Таны хөхний толгой хүүхдийн амнаас гарч ирэхдээ хавчигдсан эсвэл нэг талаараа хавтгай болсон байвал.	
Таны хөх хөхүүлсэний дараа хамаагүй илүү зөөлөрдөг.		Хөхүүлсний дараа таны хөх зөөлрөөгүй, эсвэл бэрсүүтэй, эсвэл улаан байвал.	
Хүүхэд 3-4 хоногтой болоход хөхний сүүгээ залгилж байгаа нь танд ихэнхдээ сонсогдоно.		Хөхүүлэх үедээ хүүхдийнхээ сүүгээ залгилахыг харж эсвэл сонсож чадахгүй байвал.	
		Та хүүхэддээ соосог хэрэгтэй гэж бодож байвал.	
		Та хүүхэддээ нэмэлт сүү өгөх хэрэгтэй гэж бодож байгаа бол.	

Хүүхдээ хангалттай сүү хөхөж байгааг би яаж мэдэх вэ?

Таны хүүхдийн живх эхний долоо хоногтоо өөрчлөгдөнө. Эдгээр өөрчлөлтүүдийн талаар ойлгож мэдснээр хөхөөр хооллолт хэвийн байгаа эсэхийг мэдэхэд тусална. Хэрэв та санаа зовж байгаа бол Эх баригч эсвэл Хүүхэд ба Гэр бүлийн Эрүүл Мэндийн сувилагчтайгаа ярилцаарай. Дараах жагсаалтуудаас таарч байвал багананд зөв тэмдэглэгээ (✓) хийгээрэй.							
Хүүхдийн нас	✓	Нойтон живх (Шээстэй)	✓	Бохир живх (Баастай)	✓	‘Баас’ нь ямархуу харагдах вэ?	
1-2 хоногтой		- Өдөрт 1-2 эсвэл түүнээс олон удаа нойтон живх солино. - Шээсний хүчил 4 хүртэлх хоногт нь үзэгдэж болно* (тайлбарыг доороос уншаарай).		Зунгаг гэж нэрлэгддэг хар ногоон/хар ‘давирхай шиг’ баас гарч 1 ба түүнээс олон удаа бохир живх солино.			
3–4 хоногтой		- Өдөрт 3 эсвэл түүнээс олон удаа нойтон живх солино. - Живх урьдынхаасаа илүү хүндэрч байгаа нь мэдрэгдэнэ. - Зарим нярай охидод хуурамч сарын тэмдэг үзэгдэж болох ба энэ нь хэвийн үзэгдэл юм** (тайлбарыг доороос үзээрэй).		- Баасны өнгө бор/ногоон/шар болж өөрчлөгддөг. - Баас шингэрч эхэлнэ (‘өөрчлөгдөж буй баас’).			
5–6 хоногтой		- Өдөрт 5 эсвэл түүнээс олон нойтон живх солино. - Живх хүнд болно. - Нэг удаагийн живх шээстэй болсон эсэхийг ялгахад амаргүй байдаг учир, хангалттай шээс гарсан эсэхийг мэддэг болохын тулд цэвэр живхэн дээр 2-4 халбага ус хийгээд ямархуу мэдрэгдэх/харагдах талаар баримжаа аваарай.		- Өдөрт багадаа 2 удаа шар баастай живх солино. - Баас нь нилээд усархаг байж болно.			
7–28 хоногтой		- Өдөрт 6 эсвэл түүнээс олон нойтон живх солино. - Живх хүнд болсон байна.		- Өдөрт багадаа 2 удаа бохир живх солино. - Баас нь шар өнгөтэй, 50 центийн зоос шиг болон түүнээс том хэмжээтэй болох ба ихэнхдээ усархаг, ‘ээдмэг’ төст харагдана.			
Шээсний хүчил*		Шээсний хүчил нь бараан улбар шар/улаан өнгөтэй бодис бөгөөд эхний хоёр хоногт ихэнх нярайд ажиглагддаг. Хэдийгээр энэ нь асуудал биш ч гарсан хэвээр байвал Эх баригч/ Хүүхэд ба Гэр бүлийн Эрүүл мэндийн Сувилагчдаа хандаарай. Учир нь таны хүүхэд хангалттай сүүгээ авч чадахгүй байгаагийн шинж байж болдог.					
Хуурамч сарын тэмдэг**		Эхний долоо хоногт хуурамч сарын тэмдэг үзэгдэх нь хэвийн. Энэ нь төрсний дараа ээжийн даавраас салж байгаатай холбоотойгоор нярайн үтрээнээс гардаг улаан ялгадас юм.					

220222ARR23